

БАТЛАВ: БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
МАХ-ЭКСПОРТ ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Д.БЭРЭЛХҮҮ



УЛААНБААТАР ХОТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10-Р ХОРООНД
БАЙРЛАХ МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2665441/

Хянасан:

ХУОБХГазрын Байгаль Орчны, Үнэлгээ Аудитын хэлтсийн мэргэжилтэн

З.Азжаргал

Боловсруулсан:

“Дорнын байгаль” ХХК-ийн гүйцэтгэх захирал



2024 он

Агуулга

| | |
|---|----|
| БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 4 |
| 1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | 4 |
| 1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА | 4 |
| БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 6 |
| БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ | 8 |
| ТОДОРХОЙЛОЛТ | 8 |
| БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 9 |
| БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ | 10 |
| БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 13 |
| БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ | 13 |
| БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ | 13 |
| БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 14 |
| БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 16 |
| БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР | 17 |
| БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ | 19 |
| БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ | 21 |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ | 22 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|--|----|
| Хүснэгт 1. <i>Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй</i> | 6 |
| Хүснэгт 2. <i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i> | 10 |
| Хүснэгт 3. <i>Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</i> | 13 |
| Хүснэгт 4. <i>Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</i> | 14 |
| Хүснэгт 5. <i>Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</i> | 16 |
| Хүснэгт 6. <i>Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр</i> | 17 |
| Хүснэгт 7. <i>Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</i> | 19 |
| Хүснэгт 8. <i>Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө</i> | 21 |
| Хүснэгт 9. <i>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт</i> | 23 |

Зургийн жагсаалт

| | |
|----------------------------|---|
| Зураг 1. Эскиз зураг | 5 |
|----------------------------|---|

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|--|
| Төслийн нэр: | “Мах боловсруулах үйлдвэрийн” төсөл |
| Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээ: Регистрийн дугаар : | “Мах-Экспорт” ХХКомпани 9011075004 2665441 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: | Улаанбаатар хот СХД, 17-р хороо, 1-р хороолол, 33-116 тоот, Утас: 11-354249, 11-353700 |

1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Мах Экспорт” ХХК нь 2001 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан. “Мах Экспорт” ХХК бол дотоодын хөрөнгө оруулалттай байгууллага юм. Үйлчлүүлэгчиддээ үр ашигтай, зардал багатай, байгаль орчинд ээлтэй, хөдөлмөрийн аюулгүй үйлчилгээг үзүүлэхийн тулд ажиллагсад болон техник тоног төхөөрмжөө тасралтгүй анхаарч хөрөнгө оруулалт хийж байна. Хэрэглэгчдийн шаардлага хэрэгцээг бүрэн ажиллаж байна.

Тус үйлдвэр БНСУ-ын иж бүрэн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх цех тасгууд, өдөрт 15 тонн гулууз мах, 3 тонн вакумлаж савласан бүтээгдэхүүн хөлдөөх блоклон хөлдөөгч, 1500 тон мах, махан бүтээгдэхүүн хадгалах аммиакан хөргүүртэй агуулах, иж бүрэн тоноглогдсон дотоод хяналтын лаборатортойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Манай үйлдвэр нь дотоод гадаадын зах зээлд хүнсний эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангасан, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэх зорилгоор Хэнтий аймгийн Хэрлэн суманд хоногт 150 бод, 800 бог төхөөрөх нядалгааны цех, 500 тонн мах хадгалах аммиакан хөргүүртэй агуулахтай салбар үйлдвэрийг 2008 онд байгуулсан. Тус үйлдвэрт төхөөрч бэлтгэсэн малын мах, дайврыг Улаанбаатар хот дахь төв үйлдвэрт шулж ангилан, жижиглэн савлаж, 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, уул, уурхайн компаниудад болон УБ хотын нийтийн хоолны газар, ресторанд захиалгаар нийлүүлдэг. Мөн үхэр, хонь, адууны махыг ОХУ, БНХАУ, Саудын араб зэрэг улсад экспортонд гаргадаг.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг эрхэмлэн дээдэлсэн олон улсын жишиг чанарт нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний манлай компани болох.

Үйлдвэрийн үйл ажиллагааны түүхий эд хүлээн авахаас бэлэн бүтээгдэхүүнийг хэрэглэгч захиалагчдад хүргэх хүртэлх бүх шатанд үзүүлж байгаа ажил үйлчилгээ хамарна.

Зураг 1. Байршил зураг



**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хүснэгт 1. Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй

| № | Байгаль орчны бүрдэл | Товч тайлбар |
|---|------------------------|--|
| 1 | Физик газарзүйн нөхцөл | <p>Төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлана. Улаанбаатар хот нь Монгол улсын нийслэл бөгөөд Монгол Улсын цорын ганц саятан хот. 1992 оны шинэ нутаг дэвсгэрийн хуваариар үндсэн 6, дагуул 3, бүгд 9 дүүрэгтэй, 4,704.4 км² газартай. Улаанбаатар хот Монгол улсын төв хэсэгт хуучнаар Алтан тэвшийн хөндий, өнөөгийнхөөр Туул-Сэлбийн бэлчир хөндийд, далайн түвшнээс дээш 1300-1350 метрт өндөрт Богдхан уул, Сонгинохайрхан уул, Чингэлтэй хайрхан уул, Баянзүрх гэсэн дөрвөн уулаар хүрээлэгдэн оршдог.</p> <p>Төслийн талбай нь Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутаг байрлах бөгөөд Туул гол болон Дунд голын татамд геоморфологийн мужлалын хувьд Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт, Богдхан уулын 8-р тойрогт байрлана. Тус тойргийн хувьд дундаж өндөртэй уулс нь элэгдэл-идэгдэлд орсон эгц хажуу болон ил гарсан хадан гарш бүхий шовх оройтой, уулын хажуу усанд элэгдэж үүссэн томоохон гуу жалга, судаг ихтэй. Газрын хэлбэр дүрсийн энэхүү онцлогоос шалтгаалан төсөл хэрэгжих талбайд уулын хажуугийн зөөгдлөөр үүссэн пролювийн хурдас болон делювийн хурдас голчлон зонхилж, хөрс үүсвэрийн үйл явцад оролцоно.</p> |
| 2 | Агаарын чанар | <p>Төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр байрлах агаарын чанарын харуул нь УБ 1 харуул юм. Энэхүү харуулын азотын давхар ислийн агаарыг бохирдуулагч бодисуудын хоног, сарын дундаж агууламжийн явцын муруйг байгуулж үзэхэд Азотын давхар исэл (NO₂) тогтвортой хоногийн явцтай, өглөө 8.00-11.00 болон орой 20.00-23.00 цагт хамгийн их агууламжтай болдог байна. Энэ нь хүйтний улирлын галлагаа, ялангуяа түлш шатаалттай холбоотой байж болох юм. Хүлцэх агууламж 30 мкг/м³ байдаг 6 өгөөд өвлийн саруудад түүнээс 2 дахин давсан байна. Автомашинаас хамаарсан бохирдол 2011 онтой харьцуулахад буурсан бол өмнөх оноос 1.5 дахин өссөн байна. Энэ нь цаг агаарын нөхцөл байдал, хөдөлгөөнд оролцож байгаа автомашинд эзэлж байгаа хуучин машины тоо, уулзвар замын нэвтрүүлэх чадвар, авто замын чанар, хөдөлгөөний эрчим зэрэг шалтгаануудаас шууд хамааран өсдөг байна. 2011 онд агаар дах азотын давхар исэл өндөр агууламжтай байсан бол 2012 онд буурсан үзүүлэлт харагдаж байна. 2009, 2010, 2011 онуудад дараалан буурсан үзүүлэлттэй байсан бол 2012 оны үзүүлэлтээр 10%-иар өссөн байна. Хэдий бууралттай гарсан боловч стандартаас 2 дахин өндөр хэвээр байна. Тоосонцорын хэмжээ өвлийн улиралд хүлцэх агууламжаас 3-5 дахин ихсэх хандлагатай байна.</p> |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | |
|---|--------------------------------|--|
| 3 | Гадаргын болон газрын доорх ус | Туул голын хойд салаанаас 1.2 км зайд оршино. Туул голын ус хэмжилтийн Улаанбаатар харуулын урсацын ажиглалтын мэдээнд (1945-2008) тулгуурлан жил бүрийн зарцуулгаар Туул голын тэжээлийг тогтоох урсацын гидрографын задлан ялгал хийсэн дүнгээс үзвэл олон жилийн дунджаар хайлсан цас, мөсний ус 10.2%-ийг, газар доорх ус хөрсний усны тэжээл 17.65%, хур борооны ус 72.15% тус тус эзэлж байна. |
| 4 | Хөрсөн бүрхэвч | ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн хийсэн судалгаагаар 2005 оны байдлаар Улаанбаатар хотын дэвсгэр нутгийн өнгөн хөрс хортой хүнд элементүүдээр нилээд хэмжээгээр бохирдсон байна. Хотын төв хэсэг, гэр хороолол, баруун талын дүүргийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ хотын дундаж дэвсгэр агууламжаас 3-8 дахин (2с =3.0-8.0) их буюу бохирдолттой гэсэн зэрэглэлд багтаж байна. Хөрсний ерөнхий бохирдолтын түвшин Баянхошуу, Дэнжийн Мянга, Амгалан, Шархад, Хайлаастын ам, 100 айл орчим зэрэг газруудад онцгой их буюу хотын дундаж агууламжаас 10-16 дахин их байна. Хөрсний дээжинд хөрсний эрүүл ахуйн шинжилгээг Хөрсний чанар, Хөрсөнд эрүүл ахуйн нян судлалын шинжилгээ хийх арга MNS6341:2012 стандартад заасан аргаар 0-10 см гүнд шинжилгээг хийсэн бөгөөд гарсан дүнг Байгаль Хөрс, Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS3297-1991 стандарттай харьцуулахад гэдэсний савханцар таньц 0.01, перфингенсийн таньц илрээгүй байна. Энэ нь энэхүү хөрс эрүүл ахуйн бага бохирдолттой байна. |
| 5 | Ургамлын аймаг | Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ихэнхи хэсэг нь ботаник-газарзүйн мужлалаар уулын ойт хээрийн Орхон – Сэлэнгийн дэд муж, хойт хэсэг нь Хэнтийн уулын тайгын мужид хамрагдана. Хотын нутаг дэвсгэрийн ихэнхи хэсэгт Өмнөд- Сибирь-Монголын умардын хэв шинжийн уулын тайгархаг ойтой. Төслийн нөлөөнд орших Толгойтын голын хөндийд алаг өвс – улалж - үетэнт (<i>Geranium pratense</i> , <i>Sanguisorba officinalis</i> , <i>Agropyron repens</i> , <i>Carex duriuscula</i>) зэрэг нугархаг ургамалшил зонхилох боловч антропогени нөлөөллийн улмаас ургамал бүрхэвч устан алга болсон байна. /Убугунов болон бусад 1998/ |

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ

ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгав.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах машин техник хэрэгслийн нөлөөгөөр хорт хий ялгарах, тоосжилт үүсэх ба замаас үүсэх тоосжилт нь ерөнхийдөө түр зуурын буюу механик үйлчлэлийн нөлөөгөөр хөрсний нунтаг хэсгүүд агаарт дэгдэж богино хугацааны турш агаарын тоосжилтыг нэмэгдүүлнэ.

Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл: Төсөл хэрэгжих талбайд гадаргын уст цэг байхгүй бөгөөд үйлдвэр нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байна.

Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Хөрсний үе давхаргад жижиг сайр болон хайрга чулууны агууламж ихтэй бөгөөд хөрсний эзэлхүүний 40% хүртэл тархалттай байна. Төслийн талбайн нь бүхэлдээ цементлэгдсэн байгаа бөгөөд ногоон байгууламжийн талбайд зүлэгжүүлсэн байна.

Нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл: Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Мах экспорт” ХХК-ийн “Мах боловсруулах үйлдвэрийн” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн дагуу боловсруулсан.

БҮЛЭГ 5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав. Төлөвлөгөөг доорх хүснэгтэд тусгасан.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|-----|--|---|---|-------------|--------------------------|------------|----------------------|-----------------------------|---|
| 1 | Агаарын чанар | | | | | | | | |
| 1.1 | тээврийн хэрэгсэл болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утаа | Үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утааны бохирдуулагч зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зориулалтын шүүлтүүр тавих, солих | Төслийн үед ашиглагдах тус байгууллагын тээврийн хэрэгслүүд | - | - | - | 300.0 | - | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. |
| 1.2 | Барилгын ажлын үед зам талбайгаас гарах тоосжилт | Барилгын ажлын үед зам талбайг чийгшүүлж тоосжилт тархахаас сэргийлэх | Барилгын, засвар үйлчилгээ хийж буй талбай | - | - | - | 100.0 | - | |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | | | | | | | | |
|-----|--|---|--------------------------------------|--|---|-----|---|------------------|--|
| 1.3 | Ахуйн болон бүх төрлийн хог хаягдалаас | Ахуйн болон бүх төрлийн хог хаягдлыг шатааж устгах үйл ажиллагааг хориглох | Үйл ажиллагааны явцад төслийн талбай | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны явцад гарах хогийн хэмжээ болон зардлыг тусгав. | | | | - | |
| | Хөргөлтийн технологиос | Хөргөлтийн технологийг өөрчилж агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | | 120000 мян.төг /Хөргөлтийн тоног төхөөрөмж угсралтын мэргэжлийн байгууллагуудын дундаж үнийн саналаар | | | | - | Монреалийн протоколын Кигалийн нэмэлт өөрчлөлт |
| 2 | Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| 2.1 | Хөрсний бохирдол | Үл нэвчих материалаар доторлосон ахуйн болон бохирын шингэн хог хаягдлын цэг байгуулах, ил задгай хатуу, шингэн хог хаяхгүй байх | Төслийн талбай | ш | Дотоод зардал | 1-2 | - | - | БОМТ-ний биелэлтийн тайлан |
| 2.2 | Хөрсний бохирдол | Хөрсний бохирдлын мониторинг хийх | Төслийн талбайд | Орчны хяналт шинжилгээний зардалд дэлгэрэнгүй тусгав. | | | | Төслийн турш | |
| 3 | Усан орчинд үзүүлэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх | | | | | | | | |
| | Ахуйн болон үйлдвэрийн ус | Ус ашиглах гэрээ байгуулах Усны төлбөрийг төлөх Үйлдвэр, ажилчдын унд ахуй | Үйлдвэр, ажилчдын унд ахуй | Хэрэглээгээр | | | | Усны тухай хууль | |
| 4 | Ургамлан нөмрөг, амьтан | | | | | | | | |
| 4.1 | Ургамал нөмрөгт талхагдах | Барилга байгууламж хоорондуур байрлах хөрс гадаргуугийн ургамлан нөмрөгийг талхалж гишгэхгүй байх, бүр нүцгэн газрыг ургамалжуулах, цаг агаарын | Төслийн талбай | м ² | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардалд орсон | | | | MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамалыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | | | | | | | | |
|-----|---------------------------------|---|-------------------------|---|---|---|---------------|---|---|
| | | гандуу нөхцөлд услаж тордох арга хэмжээнүүдийг авч байх | | | | | | | |
| 5 | Газрын гадарга, хэвлий | | | | | | | | |
| 5.1 | Газрын гадарга, хэвлий бохирдох | Үйлдвэрийн хашаан доторх цементлэгдээгүй хэсэг газрыг шимт хөрсөөр хучин ургамалжуулж, чимэглэлийн мод бут тарин арчилж хамгаалах | Үйлдвэрийн хашаан дотор | - | - | - | 600.0 | - | - |
| | | Нийт | | | | | 1000.0 | | |

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбай орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас батласан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцов.

Хүснэгт 3. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Нөхөн сэргээлтийн зорилго | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн үнэ мян.төг | Нийт үнэ мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|-------------|---------------------------|---|-------------------------------------|---------------------|------------------|-----------------------------|---|
| 1 | Үйлдвэр орчмын тохижилтод | Ногоон байгууламж байгуулах, Талбайд тухайн орчинд ургах боломжтой ургамал, мод бут тарих | Үйлдвэрийн талбай болон замын хажуу | - | 750.0 | Жил бүр хаврын улиралд | MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS4919-2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага” |
| Нийт | | | | | 750.0 | | |

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мах экспорт” ХХК-ийн Мах боловсруулах үйлдвэр түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй болно.

БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс Мах боловсруулах үйлдвэр нь 2024 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Мөн галын аюулгүй байдлын хор байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1000 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 4. Осол эрсдэлийг бууруулах,урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний, цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|--|--|---|---------------------------|------------|--------------------------|------------------------|-----------------------------|----------------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. Хөдөлмөр хамгаалал | | | | | | | | |
| 1.1 | Гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | Нийт ажилчид | - | - | Үйл ажиллагааны зардал | 2024 он | |
| 1.2 | | Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх | Нийт ажилчид | - | - | Үйл ажиллагааны зардал | 2024 он | |
| 2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх | | | | | | | | |
| 2.1 | Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул | Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах. | Мах боловсруулах үйлдвэр | 1 | | 250.0 | 2024 он | MNS5078-2001, MNS 5390:2004, |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | | | | | | | |
|-----|---|--|--------------------------|---|---|--------------|--|--|
| | гарах | | | | | | | |
| 2.2 | Төслийн үйл ажиллагаанд гал гарах | Галын салаа байгуулах (Сарай, хүрз, багор дэгээ, шулуун лоом, хувин 2ш, сүх, жоотуу, хөрөө, СЕ АВС-4 галын хор 2ш, хорны уут 2ш, элсний хайрцаг, галын хөнжил) | Мах боловсруулах үйлдвэр | 1 | 1 | 250.0 | | |
| 2.3 | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | Баянзүрх дүүргийн онцгой байдлын газраар галын дүгнэлт гаргуулах | | | | | | |
| | | Нийт | | | | 500.0 | | |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах суурь асуудлын нэг бол хот суурин газраас хаягдаж байгаа хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар зайлуулах, хог хаягдлаар хүрээлэн буй орчноо бохирдуулахгүй байх бодлого чиглэлтэй үйл ажиллагаа юм.

Хүснэгт 5. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|------|--------------------------------|---|-------------------------------|-------------|---------------------|-------------|------------------|---------------------|---------------------------------|
| 1 | Үйлдвэрийн болон ахуйн хаягдал | Голден эго ХХК-тай бохир ус тээвэрлэлтийн гэрээ байгуулах | Үйлдвэрийн талбай доторх | - | 56000 | 2 Сард удаа | 336.0 | тогтмол | Хог хаягдлын тухай хууль |
| | Үйлдвэрийн болон ахуйн хаягдал | МНТ эрдэнэс ХХК-тай хог хаягдлын гэрээ байгуулах | Үйлдвэрийн талбай доторх | - | 30000 | 3 сард | 120.0 | Тогтмол | |
| Нийт | | | | | | | 456.0 | | |

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Үйл ажиллагаа явагдах үед байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, байгаль орчны өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах ёстой. Үүнд тулгуурлан үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (БОХШХ)-г амжилттай хэрэгжүүлэх үүднээс итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагууд тухайлбал Байгаль орчны төв лаборатори, хөрсний химийн лаборатори, Хөдөө аж ахуйн их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Геологийн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэн болон орон нутгийн ЦУОШГ-тай хамтран ажиллах нь зүйтэй.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Хүснэгт 6. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн үнэ, мян.төг | Нийт үнэ, мян.төг | Тайлбар | Баримтлах хууль, журам, стандарт |
|----------------|---|-----------------|-----------------|--------------------------------------|----------------------|-------------------|-----------------|--|
| Агаарын чанар | | | | | | | | |
| 1.1 | Тоосжилт (PM10, PSM, PM25) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) Бохирдлын цэг | Төслийн талбайд | Жилд 2 удаа | Мониторингийн 1 цэгээс дээжлэлт хийх | - | 150.0 | Төслийн хүрээнд | MNS4585:2007 MNS3384:1982 MNS5014:2009 |
| Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | | | | | | | |
|-----|--|---|------------------|--|---|--------------|-----------------|---|
| 2.1 | Ялзмаг, рН, давсжилт, хөдөлгөөнт фосфор-Р2О5, кали-К2О, Ширхэгийн бүрэлдэхүүн, | Ажилчдын байр, авто машины зогсоол, хог хаягдлын цэг 4 байршилд | Жилд 2 удаа | 6 үзүүлэлт* 1 байршил | - | 80.0 | Төслийн хүрээнд | MNS5850:2008 MNS 4697:98 MNS4694-1998 |
| 2.2 | Хөрсний хүнд металлын бохирдол Хартугалга (Pb), Хром (Cr), Цайр (Zn), Никель (Ni), Кадми (Cd), (ГЗХ, БОХЗТЛ) Бактериологи нянг үзүүлэх | Үйлдвэрийн талбайн техник хэрэгслийн зогсоолын ойр орчмын хөрсөн бүрхэвчээс | Жилд 2 удаа | 5 үзүүлэлт* 1 байршил | - | 80.0 | Төслийн хүрээнд | |
| 3 | Гадаргын ус | | | | | | | |
| 3.1 | Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО3, хүчил НСО3, кальци Са, хлор Cl, кали К, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор В, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Мо, никель Ni, хар | Үйлдвэрлэлд ашиглагдах уснаас | Улиралд нэг удаа | Үйлдвэрлэлд ашиглагдах уснаас дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө. | - | 200.0 | Төслийн хүрээнд | MNS 5667-1:2002 MNS 0900:2005 |
| | Нийт | | | | | | | |
| | | | | | | 510.0 | | |

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Олон нийтийн оролцоог хангахын тулд төсөлтэй холбогдох мэдээллийг урьдчилан тараах, зар мэдээ хүргэх, төслийн нөлөөлөлд өртөгчид/оролцогч талуудтай уулзалт ярилцлага, хурал зөвлөлгөөн зохион байгуулж, санал асуулгыг хэзээ, хаана, хэрхэн авсан талаарх мэдээлэл (хурлын тэмдэглэл, протокол г.м), оролцогч талуудын ирцийн мэдээ зэргийг тайланд хавсаргана.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна.

Төсөл хэрэгжүүлэгч нь: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна. Олон нийтийн оролцоог хангахад шаардлагатай зардлыг хариуцна.

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилд батлагдсан БОМТ-ний дагуу хэрэгжүүлсэн тайланг боловсруулж тайлагнах хугацааг доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариусан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|-------------------------|----------------------|-------------|---------------|--------------------------|--|
| | | | 2024 он | | | | |
| | | | Сар 1.2.3. | Сар 4.5.6.7 | Сар 8.9.10.11 | | |
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч нээлттэй ажиллах. | 500.0 | Үйл ажиллагааны турш | | | БО мэргэжилтэн | “Байгаль хамгаалах тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10.1 дэх заалт, БОНХС-ын |

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | |
|--|--|-------------------------------------|--|-------|----------------------------|
| | | | | | 2013 оны А-126 тоот тушаал |
| | Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах | Үйл ажиллагааны зардал төсөвлөгдсөн | | | |
| | Нийт | | | 500.0 | |

БҮЛЭГ 13.ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ

Хүснэгт 8. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацаа тов | Тайлагнах зардал мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|------|---|--|---------------------------------------|------------------------------|--------------------------|--|------------------------|
| 1 | Нийслэлийн байгаль орчны газарт | Тайлан болон төслийн талбай дээр шалгуулах | БОМТ-ний ажлуудыг биелүүлсэн байдлаар | 11 сарын 01-ний дотор | Дотоод зардлаар | Менежер | Үйлдвэр дээр |
| 2 | Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам | Тайлангаар | БОМТ биелэлтээр | 12 сарын 10-ны дотор | | /Мэргэжлийн байгууллалатай хамтарч ажиллаж болно / | БОАЖЯам |
| 3 | | Ирэх оны БОМТ | БОМТ биелэлтээр | 12 сарын дотор | | | |
| Нийт | | | | | - | | |

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

“Мах Экспорт” ХХК нь 2001 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан. “Мах Экспорт” ХХК бол дотоодын хөрөнгө оруулалттай байгууллага юм. Үйлчлүүлэгчиддээ үр ашигтай, зардал багатай, байгаль орчинд ээлтэй, хөдөлмөрийн аюулгүй үйлчилгээг үзүүлэхийн тулд ажиллагсад болон техник тоног төхөөрмжөө тасралтгүй анхаарч хөрөнгө оруулалт хийж байна. Хэрэглэгчдийн шаардлага хэрэгцээг бүрэн ажиллаж байна.

Тус үйлдвэр БНСУ-ын иж бүрэн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх цех тасгууд, өдөрт 15 тонн гулууз мах, 3 тонн вакумлаж савласан бүтээгдэхүүн хөлдөөх блоклон хөлдөөгч, 1500 тон мах, махан бүтээгдэхүүн хадгалах аммиакан хөргүүртэй агуулах, иж бүрэн тоноглогдсон дотоод хяналтын лаборатортойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Манай үйлдвэр нь дотоод гадаадын зах зээлд хүнсний эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангасан, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэх зорилгоор Хэнтий аймгийн Хэрлэн суманд хоногт 150 бод, 800 бог төхөөрөх нядалгааны цех, 500 тонн мах хадгалах аммиакан хөргүүртэй агуулахтай салбар үйлдвэрийг 2008 онд байгуулсан. Тус үйлдвэрт төхөөрч бэлтгэсэн малын мах, дайврыг Улаанбаатар хот дахь төв үйлдвэрт шулж ангилан, жижиглэн савлаж, 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, уул, уурхайн компаниудад болон УБ хотын нийтийн хоолны газар, ресторанд захиалгаар нийлүүлдэг. Мөн үхэр, хонь, адууны махыг ОХУ, БНХАУ, Саудын араб зэрэг улсад экспортонд гаргадаг.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг эрхэмлэн дээдэлсэн олон улсын жишиг чанарт нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний манлай компани болох.

Үйлдвэрийн үйл ажиллагааны түүхий эд хүлээн авахаас бэлэн бүтээгдэхүүнийг хэрэглэгч захиалагчдад хүргэх хүртэлх бүх шатанд үзүүлж байгаа ажил үйлчилгээ хамарна.

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан.

“Мах экспорт” ХХК-ийн “Мах боловсруулах үйлдвэрийн” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн дагуу боловсруулсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав. Төлөвлөгөөг доорх хүснэгтэд тусгасан. Тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбай орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас батласан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцов.

“Мах экспорт” ХХК-ийн Мах боловсруулах үйлдвэр түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй болно. Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

ажиллана.

Төслийн орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс Мах боловсруулах үйлдвэр нь 2024 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Мөн галын аюулгүй байдлын хор байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1000 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Байгаль орчныг хамгаалах суурь асуудлын нэг бол хот суурин газраас хаягдаж байгаа хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар зайлуулах, хог хаягдлаар хүрээлэн буй орчноо бохирдуулахгүй байх бодлого чиглэлтэй үйл ажиллагаа юм.

Үйл ажиллагаа явагдах үед байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, байгаль орчны өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах ёстой. Үүнд тулгуурлан үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (БОХШХ)-г амжилттай хэрэгжүүлэх үүднээс итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагууд тухайлбал Байгаль орчны төв лаборатори, хөрсний химийн лаборатори, Хөдөө аж ахуйн их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Геологийн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэн болон орон нутгийн ЦУОШГ-тай хамтран ажиллах нь зүйтэй. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Олон нийтийн оролцоог хангахын тулд төсөлтэй холбогдох мэдээллийг урьдчилан тараах, зар мэдээ хүргэх, төслийн нөлөөлөлд өртөгчид/оролцогч талуудтай уулзалт ярилцлага, хурал зөвлөлгөөн зохион байгуулж, санал асуулгыг хэзээ, хаана, хэрхэн авсан талаарх мэдээлэл (хурлын тэмдэглэл, протокол г.м), оролцогч талуудын ирцийн мэдээ зэргийг тайланд хавсаргана.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна. Төсөл хэрэгжүүлэгч нь: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна. Олон нийтийн оролцоог хангахад шаардлагатай зардлыг хариуцна. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилд батлагдсан БОМТ-ний дагуу хэрэгжүүлсэн тайланг боловсруулж тайлагнах хугацааг доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

| № | Мэдээллийн төрөл | 2024 он мян.төг |
|---|--|-----------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1000.0 |
| 2 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв | 500.0 |
| 3 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв | 456.0 |
| 4 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах төсөв | - |
| 5 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний төсөв | 750.0 |
| 5 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв | 500.0 |

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 10-р хороонд байрлах “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

| | | |
|---|--|---------------|
| 6 | Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв | 510.0 |
| | Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв | 3716.0 |

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 3 716 000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 1 858 000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.



Огноо/Date: 2024.08.23 15:47:57

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000842808454

Системийн огноо/System Date:2024.08.23 15:40:51

| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|---|---|------------------------------|------------------|-----------|
| | 5037307003 | МАХ-ЭКСПОРТ | 1,858,000.00 MNT | 1.00 |
| / One million eight hundred fifty eight thousand tugrik / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No | Банкны нэр Bank Name | | |
| | 90 | State Fund | | |
| | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | | |
| | 100900013406 | БО нөхөн сэргээх баталгаа | 1,858,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-МАХ ЭКСПОРТ ХХК 2665441

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)



Огноо/Date: 2024.08.21 10:18:24

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000724319084

Системийн огноо/System Date:2024.04.25 14:09:55

| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|----------------------------------|---|-------------------------------|----------------|-----------|
| | 5037307003 | МАХ-ЭКСПОРТ | 500,000.00 MNT | 1.00 |
| / Five hundred thousand tugrik / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No | Банкны нэр Bank Name | | |
| | 90 | State Fund | | |
| | Дансны/Картын дугаар Account/Card number | Нэр/Name | 500,000.00 MNT | 1.00 |
| | 100200000906 | НБОГ.Хүү торгуулийн орлого | | |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Мах экспорт ххк 2665441

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

